

БАТЛАВ:  
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ  
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГЫГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

О. АМАРСАНАА

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:  
"ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗАР" ЗАХИРАЛ

ИНҮТ-ИЙН ДАРГА Э.ТӨРБАЯР,

"ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР" НИЙ ТӨВ АЙМАГ, СЭРГЭЛЭН  
СУМ, 4-Р БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИНЭ. "ОЛОН УЛСЫН ШИНЭ  
НИСЭХ БУУДАЛ, ШАТАХУУНЫ АГУУЛАХ" ТӨСЛИЙН 2024 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2628546



ХЯНАСАН:  
ХБОБЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

ПҮРЭВ. ШИНЭЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:  
"ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗАР" БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЭРГЭЖИЛТЭН

О. ОЮУНГЭРЭЛ

2024 ОН

УЛААНБААТАР ХОТЫН  
ОЛОН УЛСЫН ШИНЭ НИСЭХ БУУДАЛ,  
ШАТАХУУНЫ АГУУЛАХ ТӨСЛИЙН  
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ  
(ТӨВ АЙМАГ, СЭРГЭЛЭН СУМ)

Улаанбаатар хот  
2024 он

## АГУУЛГА

### ОРШИЛ IV

<b>БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	<b>1-1</b>
1.1 ТӨСЛИЙН БАЙРШИЛ, ОРЧНЫ ТОЙМ ЗУРАГ .....	1-1
1.2 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД .....	1-1
1.2.1 Иргэний нисэхийн ерөнхий газар (ИНЕГ) .....	1-1
1.2.2 Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК (НУБИЭ ХХК) .....	1-2
1.3 ГАЗАР ОЛГОЛТ БА АШИГЛАЛТ.....	1-2
1.4 НИСЭХ БУУДАЛД “НЬУ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ” ХХК-ИЙН ХАРИУЦСАН БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД .....	1-3
1.4.1 Аэродром.....	1-3
1.4.2 Ачаа, шуудангийн үйлчилгээний барилга .....	1-3
1.4.3 Аврах, гал унтраах албаны барилга, машин техник .....	1-4
1.4.4 Цэвэр ус хангамжийн байгууламж.....	1-5
1.4.5 Дулааны станц.....	1-5
1.4.6 Цахилгаан хангамж .....	1-6
1.4.7 Цэвэрлэх байгууламж .....	1-7
1.4.8 Авто зогсоол, дулаан зогсоол.....	1-7
1.5 НИСЭХ БУУДАЛД ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРИУЦСАН БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД .....	1-8
1.5.1 Шатахуун хангалтын алба .....	1-8
<b>БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b> .....	<b>2-1</b>
<b>БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТЗ-3</b>	
3.1 АГААРЫН ЧАНАР .....	3-3
3.2 ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УС .....	3-3
3.3 ХӨРСӨН БҮРХЭВЧ.....	3-3
3.4 ШУВУУ, ХӨХТӨН АМЬТАН.....	3-3
<b>БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ</b> .....	<b>4-1</b>
4.1 ГОЛ ЗОРИЛТ.....	4-1
4.2 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ .....	4-1
<b>БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	<b>5-2</b>
<b>БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	<b>6-9</b>
<b>БҮЛЭГ 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	<b>7-10</b>
<b>БҮЛЭГ 8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	<b>8-1</b>
<b>БҮЛЭГ 9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	<b>9-1</b>
<b>БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР</b> .....	<b>10-8</b>
<b>БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	<b>11-1</b>
<b>БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>	
12-1	
<b>ДҮГНЭЛТ А</b>	

### Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1-1. ИНЕГ-ын мэдээлэл болон гүйцэтгэх үүрэг.....	1-1
Хүснэгт 1-2. НУБИЭ ХХК-ийн мэдээлэл болон гүйцэтгэх үүрэг .....	1-2
Хүснэгт 1-3. Газар олголтын шийдвэр, гэрчилгээжүүлэлт .....	1-2
Хүснэгт 1-4. Дулааны станцын халаалтын зуухны техникийн үзүүлэлтүүд .....	1-6

Хүснэгт 1-5. Хүлээн авах бохир усны зөвшөөрөгдөх дээд хэмжээ .....	1-7
Хүснэгт 4-1. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй .....	4-1
Хүснэгт 5-1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	5-2
Хүснэгт 6-1. Орчны тохижилт нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	6-9
Хүснэгт 8-1. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	8-1
Хүснэгт 9-1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	9-1
Хүснэгт 10-1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	10-8
Хүснэгт 11-1. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө.....	11-1
Хүснэгт 12-1. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь.....	12-1
<b>Зургийн жагсаалт</b>	
Зураг 1-1. Төслийн талбайн байршил .....	1-1
Зураг 1-2. Нисэх буудлын аюулгүйн бүсийн зураг.....	1-3
Зураг 1-3. Хөөрч буух зурвас .....	1-3
Зураг 1-4. Ачаа, шууданийн үйлчилгээний барилга .....	1-4
Зураг 1-5. Зорчигч үйлчилгээний барилга .....	1-4
Зураг 1-6. Аврах, гал унтраах барилга, машин техник .....	1-5
Зураг 1-7. Цэвэр усны байгууламж.....	1-5
Зураг 1-8. Дулааны цахилгаан станц .....	1-6
Зураг 1-9. Цахилгааны үндсэн дэд өртөөний барилга.....	1-7
Зураг 1-10. Цэвэрлэх байгууламж.....	1-7
Зураг 1-11. Авто болон дулаан зогсоол .....	1-8
Зураг 1-12. Шатахууны агуулахын байгууламж,агуулахын хэрэглээний дизель түлш хадгалах 20 м <sup>3</sup> -ийн хэвтээ цилиндр ган сав .....	1-8
Зураг 1-13. ТС-1 хадгалах 2000 м <sup>3</sup> -ын босоо цилиндр ган сав .....	1-9
Зураг 1-14. Түлш суллах хэвтээ цилиндр Т-503 маркийн 50 м <sup>3</sup> сав .....	1-9
Зураг 1-15. Шатахууны агуулахын насосны станц .....	1-10
Зураг 1-16. Галын усан сан, сав хөргөх, усан хөшиг үүсгэх тоног төхөөрөмжийг байрлуулсан байдал .....	1-10
Зураг 1-17. Шатахуун ачих буулгах байгууламж .....	1-11
Зураг 3-1.Судалгааны талбай, ажиглалтын цэгүүд.....	3-4
Зураг 3-2. Агаарын хөлөгт аюул учруулах өндөр эрсдэлтэй 9 зүйлийн шувуу .....	3-4
Зураг 3-3. Аэродромын талбайд маш цөөн тоогоор тэмдэглэгдсэн амьтад .....	3-5

## ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.


2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд, БОАЖЯ-ны 2020.04.07-ний өдрийн 13/2278 тоот байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт, 2020 онд Эх монголын байгаль ХХК-ийн боловсруулсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр Олон улсын шинэ нисэх буудал, шатахууны агуулах төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон бөгөөд энэхүү 2024 оны БОМТ нь 2020 онд батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн 5 дахь жилийн БОМТ юм.

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 ТӨСЛИЙН БАЙРШИЛ, ОРЧНЫ ТОЙМ ЗУРАГ

Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт ХХК-ийн Олон улсын шинэ нисэх буудал, шатахууны агуулах төсөл нь Төв аймгийн Сэргэлэн сумын 4 дүгээр багийн нутагт үйл ажиллагаагаа явуулж байна (Зураг 1-1).



Зураг 1-1. Төслийн талбайн байршил

Төслийн талбай нь Улаанбаатар хотын төвөөс 50 гаруй км, Зуунмод хотоос 8 км зайд Төв аймгийн Сэргэлэн сум, 4 дүгээр баг, Бөхөгийн хөндийд байрлана.

### 1.2 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

“Чингис хаан” Олон улсын шинэ нисэх буудал нь олон улсын стандартыг хангасан 30 гаруй барилга байгууламжтай иж бүрэн цогцолбор юм. Эдгээр барилга байгууламжуудыг төсөл хэрэгжүүлэгч Иргэний нисэхийн ерөнхий газар болон Нью Улаанбаатартуу Интернэйшнл Эйрпорт ХХК-иуд өөрсдийн үйл ажиллагааны чиглэл тус бүрийн дагуу хариуцан ажиллаж байна.

#### 1.2.1 Иргэний нисэхийн ерөнхий газар (ИНЕГ)

Иргэний нисэхийн ерөнхий газар нь Монгол улсын иргэний нисэхийн тухай хуулиар олгогдсон эрхийн дагуу төрөөс Иргэний нисэхийн талаар зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг, үйлчилгээг хэрэгжүүлэн ажилладаг засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм.

**Зорилго:** Иргэний нисэхийн салбарт аюулгүй, үр ашигтай, тогтвортой үйлчилгээ үзүүлнэ.

Хүснэгт 1-1. ИНЕГ-ын мэдээлэл болон гүйцэтгэх үүрэг

Компанийн мэдээлэл	Гүйцэтгэх үүрэг
<ul style="list-style-type: none"> <li>Улсын бүртгэлийн дугаар: 9013001003</li> <li>Регистрийн дугаар: 2628546</li> <li>Хаяг: Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Буянт ухаа</li> <li>Утас: 976-11-282067</li> <li>Веб хуудас: <a href="http://www.mcaa.gov.mn">www.mcaa.gov.mn</a></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нисэхийн болон нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалт хийх</li> <li>Нислэгийн хөдөлгөөний удирдлага үйлчилгээ, холбоо, навигаци, ажиглатын техник тоног төхөөрөмжийн үйлчилгээ</li> <li>Нисэхийн мэдээлэл хангалтын үйлчилгээ үзүүлэх</li> <li>Иргэний нисэхийн үйлчилгээ</li> </ul>

Олон улсын шинэ нисэх буудал, шатахууны агуулах төсөл  
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024 он

Компанийн мэдээлэл	Гүйцэтгэх үүрэг
	<ul style="list-style-type: none"> <li>Нисэх буудал, газрын тусгай үйлчилгээ</li> <li>Эдийн засгийн зохицуулалт хийх</li> </ul>

### 1.2.2 Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК (НУБИЭ ХХК)

Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК (НУБИЭ ХХК) нь Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 261 дүгээр тогтоолоор Монгол талын 49 хувь, Япон талын 51 хувийн оролцоотойгоор 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдөр байгуулагдсан.

Тус компанийн 49 хувийг Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 150 дугаар тогтоолоор байгуулагдсан Хөшигийн Хөндийн Нисэх Онгоцны Буудал ТӨХХК эзэмшдэг бөгөөд 51 хувийг Японы Мицүбиши корпораци, Нарита Олон улсын нисэх буудал, ЖАТКО (Japan Airport Terminal Co., Ltd), ЖАЛУКС (JALUX Ltd.) компаниудын хөрөнгө оруулалттай тусгай зориулалтын компани болох Жапан Эйрпорт Менежмент ХХК эзэмшдэг.

*Хүснэгт 1-2. НУБИЭ ХХК-ийн мэдээлэл болон гүйцэтгэх үүрэг*

Компанийн мэдээлэл	Гүйцэтгэх үүрэг
<ul style="list-style-type: none"> <li><b>Улсын бүртгэлийн дугаар:</b> 000168199</li> <li><b>Регистрийн дугаар:</b> 3874095</li> <li><b>Хаяг:</b> Төв, Сэргэлэн, 4 дүгээр баг, Эрдэнэ-Уул, /41090/ Тахилт толгой</li> <li><b>Утас:</b> +976 71287360, 71287385</li> <li><b>Веб хуудас:</b> <a href="http://www.nubia-llc.mn">www.nubia-llc.mn</a></li> </ul>	<p>Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл нь концессын гэрээгээр хүлээн авсан барилга байгууламж, систем, тоног төхөөрөмжийг ашиглан зорчигчид болон ачаа тээш, шууданг аюулгүй, тав тухтай тээвэрлэхэд бэлдэх, нислэг үйлдвэрлэлийг дэд бүтцээр хангах юм.</p>

Зорилго: Гадаад дотоодын хотуудыг агаараар холбон, онгоцны буудлаар үйлчлүүлж буй бүх зорчигч, үйлчлүүлэгчдийн сэтгэл хангалуун, тав тухтай байх орчин нөхцлийг бүрдүүлж, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахын төлөө ажиллана.


### 1.3 ГАЗАР ОЛГОЛТ БА АШИГЛАЛТ

Олон улсын шинэ нисэх буудал барих газрын байршил, нисэх буудлын хил заагийг Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн “Тусгай хэрэгцээний газарт хамааруулах тухай” 140 дүгээр тогтоолоор анх тогтоосон бөгөөд 2016 оны 154-дүгээр тогтоолоор хилийн заагийг өөрчлөн тогтоосон байдаг.

*Хүснэгт 1-3. Газар олголтын шийдвэр, гэрчилгээжүүлэлт*

№	Хэнд	Зориулалт	Шийдвэр, дугаар	Нийт талбай
1.	Иргэний Нисэхийн Ерөнхий газар	Олон улсын нисэх буудал	Төв аймгийн Сэргэлэн сумын 3Д-ын 2020.05.06-ны А/269 дүгээр захирамж Улсын бүртгэлийн дугаар: 1419000027	1017 га
2.	Улсын тусгай хэрэгцээ		ЗГ-ын 2016 оны 154 дүгээр тогтоол / Government Resolution №154, of 2016	12084.9 га
3.	Зам, тээврийн хөгжлийн яам	Үндэсний хэмжээний томоохон байгуулалтын хэрэгжүүлэх бүтээн төсөл	ЗГ-ын 2016 оны 154 дүгээр тогтоол Гэрчилгээний дугаар: 000000004 / Government Resolution №154, of 2016 Certificate № 000000004	2400 га

Төв аймгийн Сэргэлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 65 дугаар тогтоолоор Аэродромын аюулгүйн бүсийг тогтоосон.



Зураг 1-2. Нисэх буудлын аюулгүйн бүсийн зураг

Төв аймгийн сэргэлэн сумын засаг даргын 2022.04.12-ний өдрийн А/244 тоот захирамжаар Аэродромын хяналтын цэгээс 3 км радиус дотор малтай айл бүүхыг хориглосон.

## 1.4 НИСЭХ БУУДАЛД “НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ” ХХК-ИЙН ХАРИУЦСАН БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД

### 1.4.1 Аэродром


Том оврын агаарын хөлөг хөөрч, бүүх хоёр талын оролт, гаралттай, 3600 м урттай 45 м өргөнтэй зурвас, явгалах замтай. Аэродром нь ИКАО-ийн Хавсралт 14-ийн дагуу аэродромын лавлагаа код нь 4E буюу А330/В777 ангилалд тохирно. Энэ нь олон улсын нисэх буудлын хамгийн бага шаардлага, нисэх буудлын ашиглалтын аюулгүй байдлыг дээшлүүлэх I ангиллын нарийвчлалд нийцэх юм. Агаарын хөлгүүд хоёр чиглэлд хөөрдөг, буудаг байх салхины болон геологийн тооцоололтойгоор байгуулагдсан.



Зураг 1-3. Хөөрч бүүх зурвас

### 1.4.2 Ачаа, шуудангийн үйлчилгээний барилга

Олон улсын болон орон нутгийн нислэгээр тээвэрлэгдэж ирсэн, тээвэрлэгдэж явах бүх төрлийн ачаа, шууданг нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангаж ачиж бүүлгах, тээвэрлэлтэд бэлтгэх, хүлээн авах болон хадгалах цогц үйлчилгээг Олон Улсын Иргэний нисэхийн байгууллага/ICAO/, Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооноос /IATA/ гаргасан стандарт, заавар, дүрмийн дагуу чанарын өндөр түвшинд үзүүлж байна.



Зураг 1-4. Ачаа, шууданийн үйлчилгээний барилга

Ачаа, шуудангийн үйлчилгээний барилгын хүчин чадал: 1) Байгууламжийн ашигтай талбай 3750 м<sup>2</sup>; 2) Жилд 11900 тонн карго ачаа, шуудан нэвтрүүлэх; 3) Аюултай ачааны агуулах эскпор импорт тус бүрт 28 м<sup>2</sup> талбайтай; 4) Үнэт ачааны агуулах эскпор импорт тус бүрт 28 м<sup>2</sup> талбайтай; 5) Хөргөлттэй агуулах 12 м<sup>2</sup>; 6) Хөлдөөгчтэй агуулах 44 м<sup>2</sup>; 7) Өндөр хүчин чадалтай 3 сэрээт өргөгчтэй.



Зураг 1-5. Зорчигч үйлчилгээний барилга

Барилгажилтийн нийт талбай 53,726 м<sup>2</sup> ба үүний 37,000 м<sup>2</sup> нь үйлчилгээний зориулалттай.

Жилд 2,3 сая зорчигчдод үйлчлэх хүчин чадалтай. Олон улсын зорчигчдын агаарын хөлөгт суух хүзүүвч 5, орон нутгийн зорчигчдын агаарын хөлөгт суух хүзүүвч 1, олон улсын бүртгэлийн 16, орон нутгийн бүртгэлийн 8 цэгтэй бөгөөд цаашид өргөтгөх боломжтой.

Нисэх буудлын барилгын фасад нь өндөр чанарын давхар шилэн хийцтэй тул гадна агаарын өндөр хэм дотор орон зайн агаарын хэмд нөлөөлөхгүй байхаар хийгдсэн. Шилэн дээвэртэй тул нэг ба хоёрдугаар давхарын танхимуудыг байгалийн гэрэлтүүлэгээр гэрэлтүүлдэг.

### 1.4.3 Аврах, гал унтраах албаны барилга, машин техник

ICAO-гийн 14-р хавсралт, Нисэх буудлын үйлчилгээний удирдамжийн 1 дүгээр хэсэгт заасны дагуу, 9 дүгээр категорин нисэх буудлын хувьд гал түймрийн үед шаардагдах усны хамгийн бага хэмжээ нь 24300 литр байх бол хөөсөн уусмалын хувьд шүршилтийн хамгийн бага зэрэг нь (тухайн уусмалын үйлчлэлийн төвшин В байх нөхцөлд) 9000 литр/мин байна. Иймд хамгийн багадаа 8500 литр усны багтаамжтай, эсвэл минутанд 3000 литр уусмал шүрших шүршилтийн зэрэг бүхий 3 ширхэг аврах буюу гал түймэртэй тэмцэх машин техникийг нисэх буудлын хувьд төлөвлөсөн.

“Гал унтраах багийнхан нь дохиолол хүлээн авснаас хойш харагдах орчны хүрээнд орших, замын нөхцөл сайтай зурвасын дурын хэсэгт 2 минутын дотор, агаарын хөлгүүдийн хөдөлгөөний талбай дахь бусад дурын цэгт 3 минутаас бага хугацаанд амжиж хүрэх ёстой” гэсэн ICAO-гийн удирдамжийн шаардлагын дагуу гал унтраах анги нь зурвасын дунд хэсэгт ойрхон, агаарын хөлөг зурвас руу гарах зориулалт бүхий явгалах замаар дамжин зурваст хамгийн богино хугацаанд хүрэх боломжтой газар аврах, гал унтраах барилга байрлаж байна.



Зураг 1-6. Аврах, гал унтраах барилга, машин техник

#### 1.4.4 Цэвэр ус хангамжийн байгууламж

Хөшигийн хөндийд байрлах усны эх үүсвэрийн гүний 3 худгаас ус олборлож, цэвэр ус хангамжийн байгууламжид байрлах түүхий ус хүлээн авах санд хүлээн авч  $800 \text{ м}^3$  хүчин чадалтай филтрэн системээр усыг цэвэршүүлж, ус хадгалах  $2 \times 400 \text{ м}^3$  санд нөөцөлдөг. 4 өргөлтийн насосоор дамжуулан MNS900:2018 стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар нисэх буудлын бүс дэх барилга байгууламжуудыг 24 цагийн түрш тасралтгүй хангадаг.



Зураг 1-7. Цэвэр усны байгууламж

#### 1.4.5 Дулааны станц

Дулааны станц нисэх буудлын барилгаас 4 км зайд байрладаг.



Зураг 1-8. Дулааны цахилгаан станц

Нийт 38 автомашины зогсоолтой. 2016 оноос дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Тус бүр нь 14 МВт-ын хүчин чадал бүхий 3 зуухтай, нийт 42 МВт суурилагдсан хүчин чадалтай. Үүнээс 2 зуух нь халаалтын улиралд байнгын ажиллагаанд, 1 зуух нь бэлтгэл байдалд буюу нөөцөд байхаар төлөвлөгдсөн. Нисэх буудлын барилга, байгууламжуудын халаалт, агаар сэлгэлтийн системийн халаалтын хэрэгцээг хангах зорилгоор тус бүр нь 14 мегаватт дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай, 150-170 градус параметртэй халуун ус гаргах 3 халаалтын зуухтай. Дулааны станц жилд ойролцоогоор 25,000 орчим тн хатуу нүүрсээр галлаж, 99.8 мян.м<sup>3</sup> ус зарцуулж, 80 мянга орчим МВт дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай.

Хүснэгт 1-4. Дулааны станцын халаалтын зуухны техникийн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1.	Зуухны хүчин чадал	МВт	28
2.	Жилд үйлдвэрлэх дулаан	МВт	80640
3.	Хэрэглэгчид өгөх дулаан	МВт	77760
4.	Жилийн түлшний зарцуулалт	Тн	25481
5.	Цахилгаан хөдөлгүүрийн суурилагдсан хүчин чадал	кВт	955.9
6.	Цахилгааны жилийн хэрэглээ	Мян.кВт	955.9
7.	Жилийн усны зарцуулалт	Мян.м <sup>3</sup>	99.8
8.	Зуухны ашигт үйлийн коэффициент	Хувь	0.81
9.	Түлшний хувийн зарцуулалт	Кг/МВт	316

#### 1.4.6 Цахилгаан хангамж

Шинэ нисэх буудал нь 110/10кВ-ын “Хөшигт” дэд станцаас цахилгаан эрчим хүчээр хангагддаг. 110/35/10кВ-ын Налайх дэд станцаас 119 дүгээр агаарын шугамаар, 220/110/35кВ-ын Сонгино дэд станцаас 121, 122-р агаарын шугамаар, 110/10кВ-ын Бөхөг дэд станцаас 139, 140 агаарын шугам гэсэн 3 талын тэжээлтэй. Үндсэн, салбар дэд өртөөнүүд эрчим хүчний системээс хүчдэлгүй болсон тохиолдолд 50-2250 кВ чадал бүхий дизель генераторуудаар барилгуудыг эрчим хүчээр хангана.



Зураг 1-9. Цахилгааны үндсэн дэд өртөөний барилга

#### 1.4.7 Цэвэрлэх байгууламж

Цэвэрлэх байгууламж нь хоногт 800 м<sup>3</sup> ахуйн бохир ус цэвэрлэх хүчин чадалтай бүрэн автомат удирдлагын системтэй. 2,2 км урт шугамтай, 2 өргөх станц, бохир усны 6 цооногтой.



Зураг 1-10. Цэвэрлэх байгууламж

Цэвэрлэх байгууламжид ирж буй бохир ус нь “Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, төвшинд тавих үндсэн шаардлага” MNS 4288:1995 стандартын шаардлага хангасан бохирдолтой усыг хүлээн авна. “Нийтийн аж ахуйн ажил үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөлийн хүрээнд 10 төрлийн үйл ажиллагааг эрхэлдэг байна.

Хүснэгт 1-5. Хүлээн авах бохир усны зөвшөөрөгдөх дээд хэмжээ

№	Үзүүлэлт	Хэмжээ, мг/л
1.	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, BOD	300
2.	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, COD (Mn)	200
3.	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, COD (Cr)	300
4.	Умбуур бодис, SS	300
5.	Нийт азот, TN	50
6.	Нийт фосфор, TP	5

#### 1.4.8 Авто зогсоол, дулаан зогсоол

Авто зогсоолын багтаамжийг агаарын хөлгийн хөдөлгөөний оргил цаг, нислэгийн урьдчилан тооцоолсон цагт үндэслэн тооцсон. Тус бүр 13 зогсоолтой 5 хос эгнээгээр халааслан нийт 6 халаасны зогсоолд 832 автомашин, такси зогсох боломжтой.



Зураг 1-11. Авто болон дулаан зогсоол


24 цагийн харуул хамгаалалт, камераар бүрэн тоноглогдсон 201 автомашины багтаамжтай 2 давхар дулаан зогсоолтой. Дулаан зогсоолын барилга нисэх буудлын барилгаас 400 метр зайд байрлаж байна.

## 1.5 НИСЭХ БУУДАЛД ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРИУЦСАН БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД

### 1.5.1 Шатахуун хангалтын алба

Шатахуун хангалтын алба нь шатахуун хадгалах босоо цилиндр 2000 м<sup>3</sup>-ийн 4 ширхэг ган сав, насосны станц, трансформатор, дизель цахилгаан үүсгүүрийн байр, галын усан сан 25 м<sup>3</sup> савтай, тунадас хадгалах хэвтээ 10 м<sup>3</sup> -ын 2 ширхэг далд байрлалтай сав, түлш суллах хэвтээ цилиндр 50 м<sup>3</sup>-ийн 1 ширхэг сав, агуулахын хэрэглээний дизель түлш хадгалах хэвтээ цилиндр 20 м<sup>3</sup>- 1 савтай, харуулын байр, галын усан сан, хэвтээ сав парк, цэнэглэх талбай, шатахуун буулгах төхөөрөмж, ачих төхөөрөмж, ууршуулах талбай, цэвэрлэх байгууламж, галын гидрант, автомашины болон явган хүний зам талбай, сав парк өргөтгөлийн талбай зэрэг барилга байгууламж болон тоног төхөөрөмжүүдээс бүрдэнэ.

**Шатахуун хадгалах сав:** Шатахууны агуулах нь 2 га талбайтай, ТС хадгалах Т-201, Т-202, Т-203, Т-204 маркийн 2000 м<sup>3</sup>-ийн 4 ширхэг савтай.



Зураг 1-12. Шатахууны агуулахын байгууламж, агуулахын хэрэглээний дизель түлш хадгалах 20 м<sup>3</sup>-ийн хэвтээ цилиндр ган сав

Түлш суллах хэвтээ цилиндр D-503 маркийн 50 м<sup>3</sup>-ийн 1 ширхэг сав, агуулахын хэрэглээний дизель түлш хадгалах D-603 маркийн хэвтээ цилиндр 20 м<sup>3</sup>-ийн багтаамжтай 1 савтайгаар 2017 онд ашиглалтад орсон.

Т-201, Т-202, Т-203, Т-204 тус бүр 2000м<sup>3</sup>-ын босоо цилиндр ган савыг 2016 онд листийн аргаар угсарч, савыг суллаж ёроолын бохирдлыг цэвэрлэж савны туршилт, сорилтыг хийсэн. Савыг усаар дүүргэж даралт өгч битүүмжлэл болон ачааллыг шалгасан бөгөөд савны тоног төхөөрөмжийн гагнуурын хэсгийг тусгай хөөсрүүлэгч уусмал ашиглан шалгаж сорилт туршилтыг хийсэн. Савны тойргийн дагуу бм тутамд хазайлт, суултыг тодорхойлсон ба шалгалтаар сайн дүнтэй гарч, ашиглах боломжтой гэсэн дүгнэлт өгсөн.

2000 м<sup>3</sup> босоо цилиндр ган савны үндсэн тоног төхөөрөмжүүдэд нягт, температур хэмжигч төхөөрөмж, цахилгаан автомат хаалт, амьсгалах хавхлага, хамгаалах хавхлага, шатахууны төвшин хэмжигч, температур хэмжигч, хэмжилтийн люк, дээж авах 3 хавхлага, хөөс, усаар бүтээгдэхүүний гадаргууг шүршин цацах шугам хоолой, орлого, зарлагын хоолой, автомат болон механик хаалтууд, цэвэрлэгээний люк, гэрлийн люк зэрэг орно.



Зураг 1-13. ТС-1 хадгалах 2000 м<sup>3</sup>-ын босоо цилиндр ган сав

Орчин үеийн автомат хэмжилтийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон ба савны дүүргэлт, шатахууны температур, нягтыг автоматаар хэмжих хөвүүрт камертай. Савны төвшинг гурван төвшингээс хэмжих тоноглол, галын үс, хөөсний камер, дээж авах битүүмжлэлтэй тоног төхөөрөмжтэйгээрээ давуу талтай.

**Түлш суллах хэвтээ цилиндр D-503 маркийн 50 м<sup>3</sup> багтаамжтай сав:** Уг савны гэмтэл, аваар ослын үед сав суллах хэвтээ цилиндр түлш суллах D-503 маркийн 50м<sup>3</sup>-ийн 1 сав байна. Түлш суллах хэвтээ сав нь аюулгүй үйл ажиллагааг хангасан хаалт, оч баригч, үл буцаах хавхлага, хэмжилтийн люк, амьсгалах клапан, автомат төвшин хэмжигч, орлого, зарлагын шугам хоолой, оч баригч, автомат хаалт зэрэг тоног төхөөрөмжүүдээс бүрдэнэ.



Зураг 1-14. Түлш суллах хэвтээ цилиндр T-503 маркийн 50 м<sup>3</sup> сав

Агуулахын хэрэглээний дизель түлш хадгалах D-603 маркийн хэвтээ цилиндр 20м<sup>3</sup>-ийн багтаамжтай 1 сав байна. Дизель түлш хадгалах сав нь ил байрлалтай ба бүтээгдэхүүний шүүрэлт гоожилтоос хамгаалж газар талбайг бетондсон. Гал гарсан тохиолдолд галын хөдөлгөөнт хэрэгсэлтэй, үс болон хөөсөөр унтраахаар тоног төхөөрөмж, шүүрэлт гоожилтыг шингээж авах эсгий, элс агуулсан тоног төхөөрөмжийг ойролцоо байрлуулсан.

**Насосны станц:** Түлшний агуулах нь газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулахын барилга, байгууламжийн гал тэсвэржилтийн зэргээр III зэрэглэлд хамаарна. III зэрэглэлийн агуулахын хувьд БНБД 21-03-04 насос станцын барилга дотор дизель цахилгаан үүсгүүрийг байрлуулахыг зөвшөөрдөг. Энэ тохиолдолд нэг төрлийн хэрэгцээнээс илүүгүй багтаамж бүхий түлшний савыг барилгын цул ханын гадна талд, эсхүл шатдаггүй материалаар хийсэн байгууламжид суурилуулна.

Түлшний агуулах нь 2017 онд ашиглалтад орсон гидрант насос P-301, P-302, P-303, P-304 маркийн 227 м<sup>3</sup>/цаг хүчин чадалтай 4 ширхэг, сав хоорондын D-503 маркийн 50 м<sup>3</sup>/цаг 1 ширхэг насостай. БНБД 21-03-04 агуулахын галын аюулгүйн байршлын стандартын 7.4 дүгээр заалтын дагуу тус агуулахын насосны станцын барилгын насосны тэсрэлтээс хамгаалагдсан цахилгаан хөдөлгүүр болон дотоод шаталтат хөдөлгүүрийн өрөө нь насосны өрөөнөөс 1 төрлийн галаас хамгаалах цул ханаар тусгаарлагдан хийгдсэн байна.



Зураг 1-15. Шатахууны агуулахын насосны станц

**Галын усан сан:** ТС түлш хадгалах 2000 м<sup>3</sup>-ийн багтаамжтай савнууд нь сав хөргөх суурин төхөөрөмжөөр тоноглогдсон.



Зураг 1-16. Галын усан сан, сав хөргөх, усан хөшиг үүсгэх тоног төхөөрөмжийг байрлуулсан байдал

Савны дээд бүсэд байрлах, тодорхой хэсгүүдэд хуваагдсан, ус шүрших (усыг тойруулан шүрших хэрэгслээр тоноглогдсон хоолой) цагираг, цагиргийг галын ус дамжуулах хоолойтой холбогдсон босоо болон хэвтээ хуурай хоолойнууд, гар ажиллагаатай хаалтуудаас бүрддэг. Систем нь гал түймэр гарсан тохиолдолд савны байрлалаас хамааруулан савны гадаргууг бүтнээр, хагасыг болон дөрөвний нэгийг хөргөх боломжтой. Галын усан сан нь 500 м<sup>3</sup>/цаг далд байрласан галын усан сантай, гүний усаар хангагддаг. БНБД21-03-04 агуулахын галын аюулгүйн норм дүрмийн 8.6 дугаар заалтын дагуу 1000-3000 м<sup>3</sup>-ын багтаамжтай шатахуун хадгалах савнуудад хөөсний генератор суурилуулж галын техник хэрэгсэл холбох зориулалтын хэрэгсэл бүхий төгсгөлийг нь далангийн гадна гаргасан хоолойд холбосон.

**Шатахуун ачих буулгах байгууламж:** БНБД21-03-04 ын 5.7, 5.8 зэрэг заалтын дагуу ачиж буулгах хэсгийн талбай нь ус үл нэвтрэх хатуу гадаргуутай, 0.2м-ээс багагүй өндөр хашлагаар битүү

Олон улсын шинэ нисэх буудал, шатахууны агуулах төсөл  
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024 он

хүрээлэгдсэн, шингэнийг бохирын суваг, цуглуулга урсгах зориулалтаар 2 хувиас багагүй налуутайгаар хийгдсэн.

Ачих буулгах байгууламжийн тавцангийн шатнуудыг тавцангийн 2 төгсгөл, шулуун хэсэгт хоорондоо 100 м-ээс илүүгүй зайд байрлуулна. Шатны өргөн нь нь 0.7 м-ээс багагүй, 1:1-ээс илүүгүй өгсүүр зэрэг заалтыг шаардлага хангасан байна. Тус агуулах нь Z-106 маркийн 2300 л/мин, Z-101 маркийн 1900 л/мин, Z-102 маркийн 1900 л/мин, Z-103 маркийн 2300л/мин ачих, буулгах хүчин чадалтай 4ш төхөөрөмжөөс бүрдэнэ.

Агаарын хөлгийг сумлах ажиллагаа нь зорчигч үйлчилгээний барилгын агаарын хөлгийн зургаан зогсоол дээр байрлах арван дөрвөн ширхэг гидрантын хавхлагаас түлш түгээх зориулалтын диспенсэр авто машинаар хийгдэнэ.



Зураг 1-17. Шатахуун ачих буулгах байгууламж

Нэг худаг нь нэг минутад 1,000 галлон буюу 3,780 литр хүртэл шахах техникийн хүчин чадалтай. Гурван агаарын хөлөгт нэгэн зэрэг сумлагаа хийх боломжтой.

## БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

**Физик газарзүйн нөхцөл.** Төв аймаг Монгол улсын дорнод төв хэсэгт 74,042.37 км<sup>2</sup> газар эзлэн оршдог. Газар зүйн байршлаар Хангай, Хэнтийн уулархаг, Дорно Монголын талархаг мужид багтана.

Нисэх буудал орчмын талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангай- Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн муж, түүний захын тойрогт (Ш. Цэгмид, 1969) хамрагдах бөгөөд Бага Хэнтийн нурууны урд захад орших Богдхан уулаас (Цэцээ гүн, 2256.3м) урагш намссан салбар дундаж уулсын хоорондох өргөргийн дагуу сунасан, зүүнээс баруун тийш бага зэрэг хэвгий өргөн хөндий юм.

**Хөрсөн бүрхэвч, ургмалан нөмрөг.** Нисэх буудал орчмын талбай нь Монгол орны хөрс газар зүйн мужлалтаар хөрс био-уур амьсгалын Хангайн их мужийн өндрийн бүсчлэлийн дэд бүсийн Хэнтийн захын 39- дүгээр тойрогт хамрагдана. Сайргархаг хархүрэн, ердийн хархүрэн, нугархаг хархүрэн дэд хэв шинжид хамрагдах хөрсүүд тархсан байна (Монгол Улсын Үндэсний Атлас 2009).

Нисэх буудал орчмын талбай нь ургамал-газарзүйн бүсчлэлээр хээрийн бүсэд, ургамалжилтын тойргоор Монгол Дагуурын тойргийн урд хязгаар нутаг байх тул Дундад Халхын хээрийн ургамалжилтын хэв шинжийг төлөөлнө.

Нисэх буудлын орчимд харгана оролцсон жижиг үетэн-алаг өвст, чулуусаг жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, зогдор улалж бүхий жижиг дэгнүүлт үетэн-агь бүлгэмдлүүд зонхилох болж судалгааны талбай ажлын даалгаварт заасны дагуу 15 км-ийн радиусаар тэлэх тусам ургамалжилтын хэв шинж олон янз байдалтай болно.

**Агаарын чанар.** 2023 оны агаарын чанарын шинжилгээний дүнгээр хэмжилтийн бүх цэгүүд дээр агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосны агууламж MNS:4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага стандартын хүлцэх хэмжээнд байна. Нисэх буудлын ойр орчимд дэгдэмхий органик нэгдэл илрээгүй.

Үзүүлэлт	Шинжилгээ хийсэн цэгүүд	Шинжилгээний дүн
NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , O <sub>3</sub> , H <sub>2</sub> S, CO <sub>2</sub> , CO, тоосжилт /органик биш бохирдуулагч/	-Нисэх зурвасын баруун төгсгөл орчим агаарын хөлөг хөөрөх үед	Азотын давхар исэл /NO <sub>2</sub> /, Хүхэрлэг хий /SO <sub>2</sub> /, Озон /O <sub>3</sub> /, Нүүрсхүчлийн хий /CO <sub>2</sub> /, Нүүрстөрөгчийн дутуу исэл /CO/, Нийт тоос /TSP/ органик биш бохирдуулагчийн агаар дахь хэм хэмжээ нь Монгол Улсын стандартад нийцсэн бөгөөд байх ёстой хэмжээнээс хэтрээгүй. Шинжилгээгээр хүхэрт ус төрөгч /H <sub>2</sub> S/ илрээгүй.
	-Нисэх зурвасын баруун төгсгөл орчим агаарын хөлөг буух үед	
	-Нисэх зурвасын зүүн төгсгөл орчим агаарын хөлөг хөөрөх үед	
	-Нисэх зурвасын зүүн төгсгөл орчим агаарын хөлөг буух үед	
	-Перрон талбай орчим	
	-Нисэх буудлын автомашины зогсоол	
Орчны агаар дахь ДОН-ийн шинжилгээ хийх (VOCs)	-Дулааны станцын бамбар утааны дагуу 400 метр	Нисэх буудлын ойр орчимд дэгдэмхий органик нэгдэл (VOCs) илрээгүй.
	-Дулааны станцын бамбар утааны дагуу 4000 метр	
	-Зорчигч үйлчилгээний барилгаас 100 м зайд	
	- Шатахууны агуулахын урд талд, 100 м зайд	
	- Ачаа шуудангийн үйлчилгээний барилгын зүүн урд 100 м зайд	

**Олон улсын шинэ нисэх буудал, шатахууны агуулах төсөл  
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024 он**

Үзүүлэлт	Шинжилгээ хийсэн цэгүүд	Шинжилгээний дүн
Дуу, чимээний суурь хэмжилт	<ul style="list-style-type: none"> <li>- Нисэх зурваст агаарын хөлөг хөөрөх үед</li> <li>-Нисэх зурваст агаарын хөлөг бүүх үед</li> <li>-Нисэх зурваст агаарын хөлөг хөөрч, буугаагүй үед</li> <li>-Нисэх буудлын автомашины зогсоол</li> <li>-Нисэх буудлын дулааны станц</li> <li>-Төслийн талбайн хил (зүүн тал)</li> <li>-Төслийн талбайн хил (баруун тал)</li> </ul>	Хэмжилтээр дууны даралтын дундаж түвшин нь агаарын хөлөг хөөрөх үед 72.65 дб, агаарын хөлөг бүүх үед 77.75 дб, агаарын хөлөг хөөрч буугаагүй үед 76.2 дб тус тус үзүүлэлттэй байна.”

Органик биш бохирдуулагчийг нийт 8 цэгт, орчны агаар дахь ДОН-ийн шинжилгээг нийт 3 цэгт, дуу чимээний хэмжилтийг 7 цэгт тус бүр хэмжилтийг хийсэн бөгөөд хэмжилтийн дүн хэвийн хэмжээнд байна.

**Шувуу, хөхтөн амьтан.** 2022 онд нисэх буудлын ойр орчмын 15 км радиус талбайд шувуу, хөхтөн амьтдын судалгаа хавар, намрын нүүдэл, үржлийн болон өвөлжиж буй үеийг хамруулан, олон улсад хүлээн зөвшөөрөгдөж түгээмэл ашиглагддаг “харууц сайтай цэгээс ажиглах” аргаар хийгдсэн. Нисэх буудлын орчимд Олон улсад “Устаж болзошгүй” зэрэглэлтэй идлэг шонхор, “Ховордож болзошгүй” зэрэглэлтэй нөмрөг тас, Бүс нутгийн хэмжээнд “Эмзэг” зэрэглэлтэй идлэг шонхор шувуу зэрэг 126 зүйл шувуу тэмдэглэгдсэн.

Нисэх буудлын орчимд 6 баг 14 овгийн 24 зүйл хөхтөн амьтан тэмдэглэгджээ. Үүнд, “Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсад худалдаалах тухай Конвенцийн хавсралт”-д орсон шар үнэг, саарал чоно, мануул, мий болон “Зэрлэг амьтны нүүдлийн зүйлийг хамгаалах тухай Конвенцийн хавсралт”-д орсон буурал сармаахай, дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан дансны шалгуураар олон улсын болон бүс нутгийн ховордлын зэрэглэлтэй Монгол тарвага, хярс зэрэг амьтад байна.

**Нийгэм эдийн засгийн байдал:** 2023 оны байдлаар Төв аймагт 28,845 өрхийн 92,484 хүн, Сэргэлэн суманд 779 өрхийн 1,999 хүн, 4-р багт (Эрдэнэ-Уул) 192 өрхийн 512 хүн оршин сууж байна.

Мал сүргийн тоо Төв аймагт 4,933,010, Сэргэлэн суманд 171,000, 4-р багт 17,700 толгой малтай байна. Ажиллах хүчний судалгааны 2023 оны 4 дүгээр улирлын дүнгээр аймгийн хэмжээнд 15, түүнээс дээш насны нийт хүн амын 38 700 000 нь ажиллах хүч юм. Эдгээрээс 38 200 хүн тодорхой ажил эрхэлдэг, 600 хүн тодорхой эрхэлсэн ажилгүй байна. Ажиллагчдын дундаж цалин 1 850 000 төгрөг байгаа нь улсын дунджаас 383 600 төгрөг буюу 17,2 хувиар бага юм. Аймгийн хэмжээнд нийт 1140 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Өрхийн дундаж орлого 2,3 сая төгрөг.

Төв аймгийн Сэргэлэн сумын газар нутаг 379 646 га, хүн амын тоо 2 143, айл өрхийн тоо 832, мал сүргийн тоо 170 995 бөгөөд 142 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

## БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 3.1 АГААРЫН ЧАНАР

**Агаарын чанар:** Дулааны станцын үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр агаарын чанарын хяналт шинжилгээ болон Орчны агаар дахь ДОН-ийн шинжилгээ (VOCs)- г нийт 11 үзүүлэлтээр нисэх зурвасын баруун төгсгөл орчим, автомашины зогсоолын орчим, дулааны станцын бамбар утааны дагуу 400 метрт, перроны орчим, түлшний агуулах орчим, зорчигч үйлчилгээний барилгын орчим гэсэн нийт 6 цэгт хийв. (Шинжилгээ хийсэн байгууллага “Ногоон титэм ХХК”).

Дулааны станцын хоёр зуухны яндангийн утаанд агаарын бохирдлын эх үүсвэрийн хаягдал утааны хяналт шинжилгээний хэмжилт хийв. Эдгээр шинжилгээний дүнгээр MNS4585:2016, MNS5919:2008-д заасан агаар дахь хүхэрлэг хийн, азотын давхар исэл, зуухны хаягдал утаан дахь нийт тоосны агууламж хэвийн байна. (Шинжилгээ хийсэн байгууллага “Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар”)

**Дуу шуугиан:** Дуу шуугианы хэмжилтийг нисэх буудал орчмын нийт 7 цэгт зуны болон өвлийн улиралд хийсэн. Хэмжилтээр дууны даралтын дундаж түвшин нь агаарын хөлөг хөөрөх үед 72.65 дБ, агаарын хөлөг буух үед 77.75 дБ, агаарын хөлөг хөөрч буугаагүй үед 76.2 дБ тус тус үзүүлэлттэй байна. (Шинжилгээ хийсэн байгууллага “Хэлт энд Сэфти Солушинс” ХХК).

### 3.2 ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УС

Нисэх буудлын талбайд байрлах 3 гүний худгийн уснаас дээж авч “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын стандарт” MNS 0900:2018 стандартын хүлцэх агууламжийн үзүүлэлттэй харьцуулж үзэхэд шинжлүүлсэн элементүүдийн хувьд давсан үзүүлэлт илрээгүй. Уг стандарт шаардлагыг хангасан, химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, зөөлөвтөр ус байна гэсэн дүгнэлт гарсан. (Шинжилгээ хийсэн байгууллага “Монгол Ус ТӨҮГ”-ын Усны хяналтын лаборатори, Төв аймгийн мэргэжлийн хяналтын газрын Итгэмжлэгдсэн лаборатори).


Нисэх буудлын цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгдсэн бохир усанд хийсэн бичил амь судлалын микробиологийн шинжилгээний дүнгээр уг цэвэрлэгдсэн ус стандарт шаардлагыг хангаж байна. (Шинжилгээ хийсэн байгууллага Ханлаб ХХК).

### 3.3 ХӨРСӨН БҮРХЭВЧ

Дулааны станцын нүүрс, үнсний талбайн баруун урд талд 10 метрт, авто засвар үйлчилгээний барилга, цахилгааны дэд өртөөний эвдрэлд өртөөгүй талбайн 4 цэгээс хөрсөн дэх хүнд металлуудын агууламжийг тодорхойлох шинжилгээ, хөрсний агрохимийн шинжилгээ, нисэх буудлын төвлөрсөн хог хаягдлын цэгийн орчимд хөрсний нянгийн шинжилгээг тус тус хийв. Шинжилгээний дүн MNS 5859:2008, MNS 5850:2019 стандарт шаардлагыг хангаж байна. Бактерийн ерөнхий тоо хэвийн хэмжээнд, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян болон бусад нян илрээгүй. (Шинжилгээ хийсэн байгууллага “Ханлаб” ХХК).

### 3.4 ШУВУУ, ХӨХТӨН АМЬТАН

2022 онд МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулийн судалгааны баг “Чингис хаан” нисэх буудалд төвтэй 15 км радиустай тойрог талбайд шувуу, хөхтөн амьтдын судалгаа хийсэн.



Зураг 3-1. Судалгааны талбай, ажиглалтын цэгүүд

Үржлийн үеийн судалгааны үед нисэх буудлын ойр орчим болон 15 км радиуст 62 зүйл шувуу тэмдэглэгдсэн. Үүнд: суурин 18 зүйл, нүүдлийн өндөглөдөг 19 зүйл, нүүдлийн үедээ дайрч өнгөрдөг 22 зүйл, өвөл орж ирдэг 3 зүйл шувууд. Шувуудын агаарын хөлөгтэй мөргөлдөх эрсдлийн үнэлгээний үр дүнгээр 9 зүйлийн шувуу өндөр эрсдэлтэй, 29 зүйлийн шувуу дундаж эрсдэлтэй, 69 зүйлийн шувуу бага эрсдэлтэй байна.



1. Улаан хошуут жунгаа, 2. Шилийн сар, 3. Нөмрөг тас, 4. Сохор элээ, 5. Өвөгт тогоруу, 6. Хондон ангир, 7. Хон хэрээ, 8. Гангар хун, 9. Монгол цахлай

Зураг 3-2. Агаарын хөлөгт аюул учруулах өндөр эрсдэлтэй 9 зүйлийн шувуу

Хагас жилийн судалгааны дүнгээр 6 баг 13 овгийн 22 зүйл хөхтөн амьтан тэмдэглэгдсэн.



1. бор туулай, 2. хярс, 3. шар үнэг, 4. цагаан зээр, 5. сибирь алаг даага,  
6. дагуур зараа

*Зураг 3-3. Аэродромын талбайд маш цөөн тоогоор тэмдэглэгдсэн амьтад*

Үүнээс Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан дансны шалгуураар олон улсын болон бүс нутгийн ховордлын зэрэглэлтэй Монгол тарвага, хярс, шар үнэг, саарал чоно зэрэг амьтад бүртгэгдсэн байна.

## БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ

### 4.1 ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОХТ, ОХШХ-ийг боловсруулав.

### 4.2 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

Иргэний нисэхийн ерөнхий газар ТӨҮГ-ын Олон улсын шинэ нисэх буудал, шатахууны агуулах төслийн 2024 оны БОМТ-г Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2019 оны 10-дүгээр сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу боловсруулав. 2020 онд батлагдсан БОННУ тайланд БОМТ-г хэрэгжүүлэх 5 жилийн дундаж зардалд нийт 1,480,769,000 ₮ төсөвлөсөн бөгөөд 2024 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд нийт **229,137,940** ₮ зарцуулахаар төлөвлөв.

Хүснэгт 4-1. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал (₮)	
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	45,082,000	
	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	44,500,000	
3.	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	36,614,000
4.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	60,841,440	
5.	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	22,500,000	
6.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	19,600,500
	<b>Нийт зардал</b>	<b>229,137,940</b>	

## БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

